

Co-funded by  
the European Union



switchasia



CZECH REPUBLIC  
DEVELOPMENT COOPERATION



## 'Дулаан шийдэл' төсөл (2018-2022) Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд хийсэн дүн шинжилгээ



БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТӨВ  
BUILDING ENERGY EFFICIENCY CENTER



Монголын  
Барилгын  
Үндэсний  
Ассоциаци

## Агуулга

### 1. Танилцуулга

### 2. Өрхийн ерөнхий мэдээлэл

- a. Өрхийн орлогын тархалт
- b. Өрхийн орлогын байдал
- c. Өрхийн ам бүлийн бүтэц
- d. Байшин, дулааны эх үүсвэрийн бүтэц
- e. Өрхийн үндсэн хөрөнгийн байдал
- f. Өрхийн зээл авсан байдал

### 3. Зээл авах боломжтой бүлгийн дэлгэрэнгүй мэдээлэл

- A. Өрхийн орлогын тархалт
- B. Өрхийн орлогын байдал
- C. Өрхийн ам бүлийн бүтэц
- D. Орон сууц, дулааны эх үүсвэрийн бүтэц
- E. Зээл авах боломжтой байдал
- F. Зээл авах боломжтой хэмжээ
- G. Дүгнэлт

## График зураг

**Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018**

График 1 – Өрхийн орлого, зарлагын байдал

График 2 – Өрхийн орлогын тархалт (₮)

График 3 - Өрхийн орлогын тархалт (₮)

График 4 – Өрхийн гэр бүлийн гишүүдийн тоо

График 5: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн гишүүдийн тооны тархалт

График 6 – Өрхийн орлогын түвшний тархалт

График 7 – Зээл авах боломжтой хэсгийн орлогын түвшний тархалт

График 8 – Байшингийн хэмжээгээр нь ангилсан зээл авах боломжтой хэсгийн өрхийн тооны тархалт

График 9 - Байшингийн хэмжээгээр нь ангилсан зээл авах боломжтой хэсгийн өрхийн тооны тархалт

График 10 – Гэр бүлийн гишүүдийн тоо

График 11 – Өрхийн орлогоос хамаарч зээл авах боломжтой болон боломжгүй өрхүүдийн дундаж хүүхдийн тоо

График 12 - *Зээл авах боломжгүй хэсгийн орлогын бүтэц*


График 13 - *Зээл авах боломжтой хэсгийн орлогын бүтэц*

График 14 – *Зээлийн төрлийн бүтэц*

График 15 - *Зээлийн зорилгын бүтэц*

График 16 - *Хадгаламжийн боломжит дүнгээр нь өрхүүдийг ангилсан нь*

График 17 - *Зээл авах боломжтой өрхүүдийн жилийн хадгаламжийн хэмжээ болон боломж (Хөрөнгө оруулах боломж)*



## Танилцуулга

Үндэсний Статистикийн Газар 1966 оноос хойш Өрхийн орлого зарлагын судалгааг, нийгэм эдийн засгийн судалгааг 2007 оноос хойш Өрхийн орлого зарлагын судалгааг “Амьжиргааны түвшинг хэмжих” судалгаагаар холбож судалж ирсэн. Хамгийн сүүлийн судалгаагаар 11232 өрхөөс судалгаа авч нас, хүйс, ажил, боловсролын тухай нарийвчилсан мэдээлэл цуглуулсан. Өрхийн судалгаанд өрхийн орлого, зарлага, хэрэглээг мэдэгдэх мэдээлэл цуглуулдаг. Жил ирэх тусам судалгааны асуулгууд илүү нарийвчилсан болж, нэмэгдсээр ирсэн. Гэр хорооллын айл өрхийн нийгэм эдийн засгийн байдлыг сайтар судалж үзэхийн тулд ялангуяа байшинд амьдардаг гэр бүлийг судлахын тулд бид Өрхийн орлого, зарлагын бодит мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийсэн юм. Бид дүн шинжилгээг хийхэд доорх 3 хүчин зүйлийг авч үзсэн:

- a. Бид үндсэн судалгааг бэлдэхийн тулд гэр хорооллын өрхүүдийн орлогын эх үүсвэр, зарлага, үндсэн хөрөнгө, эзэмшсэн зүйлс, ядуурал, түүнээс улбаалсан нийгмийн шинж чанар гэх мэдээллийг тооцсон. Ингэснээр бид зээл авах боломжит мөн боломжгүй хэсгүүдийг тодорхойлж хооронд нь харьцуулсан<sup>1</sup>.
- b. Бид мөн зорилтот өрхийн үндсэн судалгаа хийхийн тулд үл хөдлөх хөрөнгө, байшин, дулааны эх үүсвэр, хэмжээ гэх мэтийг судалсан. Мөн боломжит болон боломжгүй хэсгийн хооронд ялгаа байгаа эсэхийг шалгасан.
- c. Бид эцэст нь гэр бүлийн гишүүдийн тоо өрхийн орлого, зарлагад нөлөөлж буй эсэхийг судалсан.

Урьд дурдсанаар бид 11232 айлын дунд судалгаа явуулсны 1174 нь байшинд амьдардаг өрхүүд байсан.

## Өрхийн ерөнхий мэдээлэл

### *Өрхийн орлогын тархалт*

График 1 гэр хорооллын судалгаанд хамрагдсан хүн амын нэг жилийн орлогын хувийг харуулж байна. Орлого өрхүүдийн дунд тэгш бус байдлаар хуваарилагдсан нь харагдаж байна. Ерөнхий байдлыг авч үзвэл их орлоготой 8.5% нийт орлогын 22.3%-ыг олж байхад бага орлоготой 46%-ын өрхүүд мөн 22.3%-ын орлогыг олж байна. Үлдсэн

---

<sup>1</sup> Зээл авах боломжгүй өрхүүд – Өөрсдийн үндсэн санхүүгийн хэрэгцээг хангах боломжгүй болон авсан зээлийн хэмжээ нь хэтэрсэн өрхүүд

55.4%-ыг дундаж орлоготой 45.5% олж байна. Их орлоготой 10%, бага орлоготой 10% хэсэг бүлгүүдийн орлогын харьцуулалт хоорондоо маш тэгш бус хуваарилалттай байна.

The bottom 10% households only get 1.3% of total income while top 10% receive much higher share of income at 22.3%.




График 1: Өрхийн орлого зарлагын байдал (Х-тэнхлэг өрхүүдийн орлогыг харуулж байгаа бол Y-тэнхлэг өрхийн жилийн орлогыг сая ₮-өөр харуулж байна. )

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018

### Өрхийн орлогын байдал

400,000 ₮-өөс бага орлого олдог өрхүүд судалгаа хийсэн өрхүүдийн 25%-ийг эзэлж байгаа бол үлдсэн хувийг 500,000-600,000, 700,000-800,000 ₮ олдог өрхүүд эзэлж байна. 1,500,000₮ олдог айл өрх зөвхөн 7%-ийг эзэлж байна. Энэ судалгаанд богино хугацааны ажлын орлогыг орлогот тооцоогүй. Судалгаанд хамрагдсан айл өрхийн ихэнх нь 400,000-800,000₮-ийн орлого олдог бол дундаж орлого нь 812,000₮ байна. Энэ нь гэр хорооллын айл өрхийн орлогын байдал тун харьцангуй байгааг харуулж байна. Тийм учраас зээл авах боломжтой хэсэг бүлгийг зөвхөн орлогоор нь харьцуулж сонгох нь хангалттай үзүүлэлт биш гэдгийг баталж байна.




График 2: Өрхийн орлогын тархалт (₮)

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018

Бид энэ графикт орлогын тархалтыг харуулахаар зорьсон. Бид хувиар харуулахын тулд нэмэлт графикыг нэмсэн.




График 3: Өрхийн орлогын хуваарилалт (₮)

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018

## Өрхийн ам бүлийн бүтэц

Гэр хорооллын байшинд амьдардаг гэр бүлийн гишүүдийн дундаж тоо нь 4,2 байна.




График 4: Гэр бүлийн гишүүдийн тоо




График 5: Судалгаанд хамрагдсан гэр бүлийн гишүүдийн тоон тархалт  
Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018

## Байшин, дулааны эх үүсвэрийн бүтэц

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн амьжиргааны түвшин, амьдралын чанар нь байшингийн бүтэц болон энгийн хэрэглээний боломжтой байдлаас дан хамаарахгүй байна.

Ихэнх байшин тоосгоор (тоосго/мод) 58% барьсан байхад модоор (мод/шавар) барьсан байшин 25%-ийг, хөнгөн блокоор барьсан байшин 12%-ийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан айл өрхийн ихэнх буюу 80.5% нь нэг буюу хоёр өрөөтэй байшинд амьдарч байна. Айл өрхийн дундаж ам бүл 4 байгаа учраас амьдрах орон зай хангалттай хүрэлцэхгүй байна. Эдгээр айл өрхийн 80% нь зуух хэрэглэдэг бол 16.8% зуух болон усаар халаах холимог систем хэрэглэж байна. Үлдсэн 3.2% нь цахилгаан халаагуур хэрэглэдэг гэж судалгаанд бүртгэгджээ. Дээрх өрхийн 96.8% нь түүхий нүүрсийг гол түлшээ болгож хэрэглэдэг. Гэр хорооллын айл өрхүүд төв ус, халаалт, бохирын шугамд огт холбогдоогүй байна.

Гэр хорооллын айл өрхийн нэг сарын орлого 300,000-5,000,000-ын хооронд хэлбэлзэж байгаа хэдий ч өрхийн орлого, байшингийн бүтцийн хооронд ямар нэгэн харилцан хамаарал байхгүй байна. Ялангуяа 300,000-900,000₮ сард олдог өрхүүдийн (62%) дунд дараах шалтгаанаас болоод ил харагдахуйц харилцан хамаарал байхгүй байна:

- Бэлэн материалын хомсдолоос болж судалгаанд хамрагдсан байшингуудад маш цөөхөн төрлийн зураг төсөл байна;
- Гэр хорооллын байшин барих тогтсон дүрэм журам, арга барил, стандарт байхгүй байна;

### ***Өрхийн үндсэн хөрөнгийн байдал***

Судалгаанд хамрагдсан айл өрхийн үндсэн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ 31,278,000₮ байна. Эдгээр өрхийн 89% нь өөрсдийн газрыг өмчилдөг бол 10%-аад хувь нь газраа өмчилдөггүй.


### ***Өрхийн зээлийн байдал***

Айл өрхийн 39% нь зээл авсан бөгөөд тэдний зээлийн дундаж хэмжээ 3,400,000₮ байна. Тэдний 99.8% нь банкнаас зээл авсан байна. Гэвч үлдсэн хэсэг нь найз нөхөд, гэр бүлийнхэн, ломбард гэх зэрэг газраас албан бусаар зээл авсан бөгөөд энэ төрлийн албан бус зээл авах тохиолдол ихсэж байна. Зээлийн хэмжээний 68% нь хувийн хэрэглээ, нийгмийн үйл ажиллагаанд зориулагдсан бол 19.5% нь тавилга, багаж хэрэгсэл, 10% нь бизнест, 3% нь байшиндаа зарцуулагдсан гэсэн тооцоо гарчээ.


### **Зээл авах боломжтой хэсгийн дэлгэрэнгүй мэдээлэл**

400,000₮-ийн орлоготой өрхүүд илүү мөнгө хөрөнгө оруултанд зарцуулж чадахгүй гэдэг нь эндээс тодорхой харагдаж байна. Цөөн тооны ам бүлтэй, зарлага бага гаргадаг 20%-ийн айл өрхүүд мөнгө хадгалах боломжтой харагдаж байна. Тэд хадгаламж үүсгэх боломжтой хэдий ч жилийн нийт хадгаламж нь хамгийн ихдээ 600,000₮ болохоор байна.

Нөгөөтгээгүүр айл өрхийн орлого ихсэх тусам зээл авах боломжтой өрхийн тоо нэмэгдэж байна. Гэвч маш олон зээл авах боломжгүй, зээлийг болох бүх хэмжээнд нь авсан эсвэл зарлага ихтэй айл өрхүүд байсаар байна.



*График 6: Өрхийн орлогын хуваарилалт*



*График 7: Зээл авах боломжтой өрхүүдийн орлогын хуваарилалт*

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018*

### ***Байшингийн бүтэц***

Байшингийн хэмжээ нь үндсэн болон нэмэлт орлогоос огт хамаарахгүй байгаа нь харагдаж байна. Байшин барих хязгаарлагдмал арга барил болон ховор материалаас хамаарч

цөөхөн төрлийн байшингийн бүтэц байна. Боломжит хэсэг бүлэг өрхийн цөөн тооны гэр бүл хоёр давхар байшинтай. Гэвч ийм төрлийн байшин маш ховор байна.

Байшингийн дундаж хэмжээ 48м<sup>2</sup> бөгөөд зээл авах боломжтой хэсгийн 50%-ийн байшингийн хэмжээ нь 40-60м<sup>2</sup> –ийн хооронд байна. Гэр бүлийн гишүүдийн тоо мөн байшингийн хэмжээнд хамаарахгүй байгаа нь харагдаж байна. Гэр хороололд амьдардаг иргэдийн нягтаршил бага. Гэр бүлийн гишүүдтэйгээ хамт амьдрахаас илүү гэр хороололд амьдардаг иргэд шинэ байшин, гэр барьж орох сонирхолтой байна.




График 8: Байшингийн хэмжээгээр нь ангилсан зээл авах боломжтой хэсгийн өрхийн тооны хуваарилалт

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018




График 9: Байшингийн хэмжээгээр нь ангилсан зээл авах боломжтой хэсгийн өрхийн тооны хуваарилалт

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018

## Гэр бүлийн бүтэц

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн гишүүдийн дундаж тоо нь 4 байсан. Гэвч гэр бүлийн бүтэц өөр хоорондоо их ялгаатай байсан. Гэр бүлийн бүтэц нь:

- 2 хүүхэдтэй хосууд;
- Хүүхэд, өндөр настай хүмүүстэй амьдардаг өрх толгойлсон эцэг, эхүүд;
- Ач, зээ нартайгаа амьдардаг өндөр настай хүмүүс;
- Өндөр настай хүмүүс

Гэвч бид илүү дэлгэрэнгүй судалгаагаар тодорхой харуулах хэрэгтэй болсон.





График 10: Гэр бүлийн гишүүдийн тоо


Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018



### График 11: Зээл авах боломжтой өрхийн гэр бүлийн бүрэлдэхүүний хуваарилалт

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018

График 10, 11-ээс харахад судалгаанд хамрагдсан өрхүүдийн 50% нь 3-4 ам бүлтэй айл өрхүүд байна. Зээл авах боломжтой бүлэг, хэсгүүд 3 болон түүнээс дээш ам бүлтэй байхад бусад нь 3-аас дээш ам бүлтэй байх нь элбэг байлаа.




### График 12: Зээл авах боломжтой болон боломжгүй бүлэг өрхүүдийн хүүхдийн дундаж тоо өрхийн орлогын дагуу

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018

График 12-аас харахад хүүхдийн тоо өрхийн чадамжид их нөлөөлдгийг харж болно. Өрхийн орлого 1,000,000₮-өөс бага байхад хадгаламж үүсгэх нөхцөл байдалд хүүхдийн тоо маш их нөлөөлж байгааг харж болно. Нөгөөтээгүүр, орлого өсөх тусам хүүхдийн тоо нөлөөлөхгүй байгаа нь бас энд харагдаж байна.


### Өрхийн орлогын бүтэц

Нийгэм, эдийн засгийн судалгаанд өрхийн улирлын болон түр хугацааны ажлын орлогыг огт тооцоогүй. Мөн зарим ажил олгогчид цалингаа дан бэлэн мөнгөөр эсвэл хааяа бэлэн мөнгөөр төлдөг тохиолдлууд байсан. Судалгаанаас харахад тэтгэврийн орлого өрхийн орлогын маш чухал хэсэг болох нь мэдэгдэж байсан. Өрхийн ихэнх зарлагыг тэтгэврийн орлогоор шийдэж байсан айлууд бас байсан. Дараах график өрхийн орлогын бүтэц, ялангуяа 54% нь тэтгэврийн орлогоос хамаардгийг харуулна. Цалин, тэтгэврээс хамтран бүрдсэн орлоготой айлууд хадгаламж үүсгэх боломжтой байна.



*График 13: Зээл авах боломжгүй бүлгийн орлогын бүтэц*

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018*



*График 14: Зээл авах боломжтой бүлгийн орлогын бүтэц*

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018*

### *Accessibility to loan*

Судалгаанаас харж байхад эдгээр өрхүүдийн 50% нь зээлийн үлдэгдэлтэй байна. Эдгээр өрхүүдийн 38% нь цалингийн зээлтэй бол 25% нь тэтгэврээ барьцаалсан зээл болон бас бус лизингийн зээлүүдтэй байна. Эдгээр өрхийн 4% нь авсан зээлээ байшингаа худалдаж авахад зориулжээ. Зээл авах боломжтой өрхүүдийн ихэнх хэсэг нь зээлийн үлдэгдэлгүй байна. Гэвч эдгээр боломжтой өрхүүдийн 25% нь идэвхтэй зээлдэгчид бөгөөд нэмэлт зээл авах боломжтой гэж гарчээ.




График 15: Зээлийн төрөл

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018




График 16: Зээлийн зориулалтын хуваарилалт

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018

График 16 өрхийн авсан зээлийн зориулалтыг харуулна. Өрхүүдийн 54% нь түр хугацааны зээл авсан бол 10% нь машин гэх мэт хэрэглээний зээл авчээ. Эдгээр өрхийн 9% нь байшингаа засаж сайжруулахад зориулж зээл л авчээ. Зээлийн бусад зориулалт тодорхойгүй байна.

### Зээлийн боломжит хэмжээ

Бид судалгаагаар дамжуулан зээл авах боломжтой өрхүүд хэдэн төгрөг хадгалах боломжтой эсэхийг мэдэж авахыг зорьсон. Үүнийг мэдэж авахын тулд бид бүх зардал, зээлийн буцаан төлөлтүүдийг нийт орлогоос хасаж тооцсон. Гэр хорооллын айл өрхүүд нэмэлт орлого олох арга барил ховор учир хараахан хадгаламжгүй байна. Банканд мөнгөө хадгалуулж байснаас бусдад зээлэх эсвэл үнэт эдлэл худалдаж авахыг илүүд үздэг байна.




График 17: Өрхүүдийн хадгаламж үүсгэх боломж

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018

График 17 хадгалах боломжтой хэмжээг харуулж байна. Эдгээр өрхүүдийн 50% нь зарлага нь орлогоосоо давсан үзүүлэлттэй байна. Үлдсэн 45% нь мөнгөө хадгалах боломжтой боловч хэмжээ нь өөр өөр байх боломжтой.




График 17: Зээл авах боломжтой өрхүүдийн жилийн хадгаламжийн боломжит хэмжээ

График 17 нь зээл авах боломжтой айл өрхүүдийн хадгаламжийн боломжит хэмжээг харуулна. Графикийн дээр хэсэгт хамаарах айл өрхүүд доор жагсаасан айлуудаас илүү мөнгө хадгалах боломжтой. Эдгээр өрхүүдийн 50% нь хамгийн багадаа жилд 1,500,000-2,000,000₮ хадгалах боломжтой бол 65% нь 1.000,000-1,500,000₮ хадгалах боломжтой.

## **Дүгнэлт**

Гэр хорооллын айл өрхийн орлого Улаанбаатар хотын бусад хэсэгт амьдарч байгаа өрхүүдийнхээс арай бага. Нийт айл өрхийн 50%-аас дээш хэсэг нь өөрсдийн үндсэн санхүүгийн хэрэгцээгээ хангах боломжгүй, тийм ч учраас хадгаламж үүсгэх боломжгүй байна. Гэвч үлдсэн 45%-д багтах айл өрхүүд орлого зарлагаасаа хамаарч өөр өөр үзүүлэлттэй байна. Мөн тэдэнд хадгаламж үүсгэх мөнгө болон илүү хэмжээний зээл авах боломжтой байна.

Гэр хорооллын байшингууд загвар, барих арга барилаараа хоорондоо төстэй боловч ямар барилгын материалаар барьснаасаа хамаарч өөрчлөгдөнө.

Судалгаанаас харахад байшингийн хэмжээ, бүтэц, барилгын материал өрхийн орлоготой шууд хамааралгүй байдал нь байшин барих цөөхөн арга барил, муу чанарын барилгын материал сонгосон байдлаас харагдана.

Мөн дахин хэлэхэд бүх өрхүүдийн 80% нь энгийн зуух хэрэглэж байгаа бол 97% нь түүхий нүүрсийг гол түлшээр сонгон хэрэглэж байна.

Эдгээр өрхийн 85% нь газраа өмчилж байгаа бол 15 % нь бусдын эсвэл аав ээжийн газар дээр байшин гэрт амьдарч байгаа учраас газраа хараахан өмчилж амжаагүй байна.

Зарим айл өрхүүд орлого сайтай боловч зардал, зээлийн буцаан төлөлтөөсөө хамаарч хадгаламж үүсгэх боломжгүй байна. Тийм учраас зээл авах боломжтой айл өрхийн боломж чадамжийг зардал, зээлийн буцаан төлөлтийн дараа тодорхойлох нь илүү дээр гэдгийг харуулж байна. Хадгаламж үүсгэх боломжтой айл өрхүүд хадгаламжгүй эсвэл банканд хадгалуулсан мөнгө байхгүй байна.

Гэр хорооллын айл өрхүүдийн бүрэлдэхүүн дунджаар 3-4 хүнээс бүрдэж байгаа боловч олон хамаатан садантайгаа амьдрах тохиолдол ховор байна. Тэд олуулаа амьдарч байснаас шинэ байшин барих, өөр газар луу нүүх сонирхолтой байна. Хэрвээ бид зээл авах боломжтой хэсэг бүлгийн айл өрхүүд дараагийн хоёр жилийн хадгаламжаа зориулах боломжтой гэж үзвэл тэдний 50% нь нэг жилд 1,500,000-2,500,000₮, хоёр жилд 4,000,000-6,250,000₮ хадгалах боломжтой байна.

Үүнээс хамаарч бид дулаалгын багцаа 5,000,000₮-ийн ойролцоо байвал тохиромжтой гэж үзсэн. “Дулаан шийдэл” төслийн баг илүү хямдхан дулаалгын багц боловсруулах хэрэгтэй. Нөгөөтгээгүүр, байшингаа дулаалах сэдлийг нь төрүүлэх өдөөгч болох бага хүүтэй зээл, хямдхан мэргэжлийн зөвлөгөө, барилгын материалын хямдрал зэргийг санал болгох нь чухал байна.

Co-funded by  
the European Union



switchasia



# ЖЭРЭС ОУТББ 2019



БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТӨВ  
BUILDING ENERGY EFFICIENCY CENTER

